



**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	7
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	8
2.8.3	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3.	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
5.	Хавсралт.....	19
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ХУД	Хан-уул дүүрэг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.25 № 01/584
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ
ГЕНЕРАЛ Т.БАДРАЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР





2 Аудитын тайлан

2.1. Оршил

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч, хошууч генерал Т.Бадрал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 11-нээс 2019 оны 03 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Энхдалай, аудитор Ц.Цэрэнхүү нар хариуцаж хэрэгжүүлэв.

Онцгой байдлын ерөнхий газар 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 9/417 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.



2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад, дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Онцгой байдлын ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Онцгой байдлын ерөнхий газар нь Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхийг нэмэгдүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг болзошгүй гамшгийн аюулаас хамгаалах
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах

Онцгой байдлын ерөнхий газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль



Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Онцгой байдлын ерөнхий газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Онцгой байдлын ерөнхий газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Онцгой байдлын ерөнхий газрын дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Онцгой байдлын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Онцгой байдлын ерөнхий газрын дотоод аудитын алба харьяа 8 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийжээ. Аудитаар нийт 21.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, уг зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Онцгой байдлын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.



2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2.0 хувиар сонгов.

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн нь 123,079.1 сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 2,461.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн нэгтгэсэн тайлан, балансын дансанд хийсэн эрсдэлийн үнэлгээг үндэслэн материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 2.0 хувиар тооцсон.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 39 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдэж, аудитад бүрэн хамрагдсан байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн
1	ТШЗ	31	4	4
2	ТӨААН			
	Дүн	31	4	4

Аудитаар 29 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 2 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал, дүгнэлт өгсөн байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 3,839.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 76.9 хувь буюу 2,952.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 23.1 хувь буюу 887.4 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 1,274.9 сая, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлээр 2.952.4 сая төгрөгийн алдааг залруулсан болно.



Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

(сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	102	1,713.7	14	38.9	21	1,048.9	67	625.9	1	-	-	-
2	ТӨААН												
3	ТТЗ	2	887.4					2	887.4	-	-	-	-
	Дүн	104	2,601.1	14	38.9	21	1,048.9	69	1,513.3	-	-	-	-

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь барилга байгууламж, газрыг дахин үнэлгээнд хамруулаагүй, эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого хийгээгүй, Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газар нь санхүүгийн тайланг алдаатай бэлтгэсэн, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтгүй гүйлгээг бүртгэлд тусгасан зэрэг зөрчлүүд аудитаар илэрч, Хязгаарлалттай санал, дүгнэлт өгсөн байна.

2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгасан болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Швейцарийн хөгжлийн агентлагаас Онцгой байдлын ерөнхий газартай хамтран “Монгол Улсын хот дахь эрэн хайх, аврах ажиллагааны чадавхийг бэхжүүлэх нь” төслийг 2017 оны 5 дугаар сараас 2018 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэлх 1.8 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн. Энэхүү төслийн хугацаанд Онцгой байдлын ерөнхий газрын Төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн 100900031405 дугаарын дансанд нийт 255.0 сая төгрөгийн санхүүжилт төвлөрсөн бөгөөд үүнээс 130.2 сая төгрөгийг зарцуулж, 121.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.



2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Онцгой байдлын ерөнхий газарт үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулан 86,200.7 сая төгрөгийн төсөв батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлын нийт гүйцэтгэл 81,200.9 сая төгрөг буюу 94.2 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 4,238.8 сая, байр ашиглалтын зардлыг 177.9 сая, хангамж бараа материалын зардлыг 8.6 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 0.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийн зардлыг 46.8 сая, бараа ажил, үйлчилгээний бусад зардлыг 7.6 сая, тэтгэмж урамшууллын зардлыг 2.6 сая, хөрөнгийн зардлыг 514.9 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Онцгой байдлын ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тайлант онд Онцгой байдлын ерөнхий газрын урсгал төсвийн, нэмэлт санхүүжилтийн, хөрөнгө оруулалтын, барьцаа хөрөнгийн дансны холбогдох мэдээллүүдийг шилэн дансны сайтанд тухай бүр бүрэн оруулсан байна. Мөн албан хаагчдад зориулсан мэдээллийн самбарт байгууллагын тухайн жилийн батлагдсан төсөв, сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, цалингаас бусад 5.0 сая төгрөгнөөс дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээ, бусад мэдээллийг байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 80 хувьтай байгаа ба 1 зөвлөмж нь хэрэгжих шатандаа байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 9/258 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэл болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ



холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Онцгой байдлын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хөрөнгө оруулалт, их засварын санхүүгийн тайлан, тодруулгыг тулган шалгахад ХУД-ийн Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах 65 дугаар ангийн барилга, угсралтын ажлыг "Назу констракшн" ХХК 2011-2016 онд хийж гүйцэтгэсэн боловч гадна зам талбайн тохижилтын ажлаа хийгээгүй, уг барилгыг Улсын комисст хүлээлгэж өгөөгүйгээс 859.2 сая төгрөгийн барилга дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй байна.

Эрсдэл:

Үндсэн хөрөнгийг бүртгэлд дутуу тусгах,

Зөвлөмж:

Улсын комиссын хүлээж авсан актыг үндэслэн уг барилгыг Үндсэн хөрөнгийн холбогдох стандарт, заавар, журмын дагуу данс бүртгэлд тусгах,

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан нар хүлээн зөвшөөрсөн болно.



2. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан 2013-2015 онд үүссэн 4 аж ахуйн нэгжтэй холбоотой 14.2 сая төгрөгийн, 2 иргэнтэй холбоотой 13.9 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Эрсдэл:

Өр, авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байх,

Зөвлөмж:

Авлагыг барагдуулах, тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх,

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан нар хүлээн зөвшөөрсөн болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.



4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	102,763,079.2	103,980,590.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	116,803.1	244,033.3
33	АВЛАГА	5,653,106.4	4,338,902.2
34	УРЬДЧИЛГАА	176,451.8	368,900.3
35	БАРАА МАТЕРИАЛ	26,514,995.8	26,487,969.8
36	НӨӨЦИЙН БАРАА	70,301,722.1	72,540,784.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	117,532,352.6	164,363,361.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	117,532,352.6	164,363,361.9
39200	Биет хөрөнгө	117,507,974.1	139,453,629.9
39300	Биет бус хөрөнгө	24,378.4	24,909,732.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	220,295,431.7	268,343,952.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,136,669.0	6,114,472.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,136,669.0	6,114,472.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	217,158,762.7	262,229,480.0
51	Засгийн газрын хувь оролцоо	217,158,762.7	262,229,480.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,705,262.3	50,966,768.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	220,295,431.7	268,343,952.3



4.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	174,120,792.6	106,270,647.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,960,075.0	11,048,773.4
120	Нийтлэг татварын бус орлого	74,456,121.5	11,048,773.4
122	Тусламжийн орлого	503,953.6	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	99,160,717.6	95,221,874.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	73,693,737.3	81,461,408.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,466,980.2	13,644,847.2
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	115,618.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	154,069,466.3	114,151,811.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,362,799.9	103,434,122.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,358,897.6	83,800,221.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,340,334.3	43,380,379.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,334,096.3	1,511,430.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,109,911.7	3,490,849.5
2104	Хангамж, бараа материалын зардал	4,026,310.7	4,170,769.7
2105	Нормативт зардал	2,706,260.3	4,439,964.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,270,023.4	1,629,432.1
2107	Томилолт, зочны зардал	2,059,281.1	1,649,529.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,794,784.7	4,107,739.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,717,895.2	19,420,127.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,003,902.3	19,633,901.8
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	55,600.2	55,600.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,521,589.8	12,234,488.9
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,426,712.3	7,343,812.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,706,666.4	10,717,689.0
2200	Дотоод эх үүсвэрээр	48,706,666.4	10,717,689.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	20,051,326.3	(7,881,164.4)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	530,452.6	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,005,806.3	8,927,267.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	12,575,972.6	(16,808,431.7)



4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	103,634,216.6	104,394,898.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,462,055.8	6,797,653.2
120	Нийтлэг татварын бус орлого	4,413,761.5	6,797,653.2
122	Тусламжийн орлого	48,294.3	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	99,172,160.8	97,597,245.4
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	73,693,737.3	81,461,408.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,466,980.2	16,020,557.4
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,443.2	115,280.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,399,380.1	93,465,162.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,399,380.1	93,465,162.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	76,696,285.3	76,162,554.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,248,057.1	43,365,319.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,374,539.1	1,536,376.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,158,477.0	3,696,453.2
2104	Хангамж, бараа материалын зардал	2,808,580.8	2,870,359.3
2105	Нормативт зардал	3,614,268.4	4,090,753.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	981,600.3	1,395,724.1
2107	Томилолт, зочны зардал	2,050,207.5	1,555,239.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,905,728.8	4,428,889.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,554,826.3	13,223,439.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,703,094.8	17,302,607.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	17,234,836.5	10,929,736.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	17,192,452.8	10,802,506.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,192,452.8	10,802,506.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(17,192,452.8)	(10,802,506.3)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	42,383.7	127,230.2
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	74,419.3	116,803.1
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	116,803.1	244,033.3



4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө өмчийн дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,917,495.8		205,917,495.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-661,917.8		-661,917.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	205,255,578.0		205,255,578.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-672,787.9		-672,787.9
Тайлант үеийн үр дүн	12,575,972.6		12,575,972.6
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	217,158,762.7		217,158,762.7
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	217,158,762.7		217,158,762.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,084,575.2		-1,084,575.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	216,074,187.5		216,074,187.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	35,561,264.7		35,561,264.7
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	3,015,064.8		3,015,064.8
Тайлант үеийн үр дүн	7,578,963.0		7,578,963.0
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	262,229,480.0		262,229,480.0



4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,200,696.0	81,200,913.8	4,999,782.2	94.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	75,458,753.8	70,973,856.9	4,484,896.9	94.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,572,734.1	61,090,439.4	4,482,294.7	93.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,949,393.9	43,172,665.9	2,776,728.0	94.0
210101	Үндсэн цалин	31,914,026.7	29,910,846.6	2,003,180.1	93.7
210102	Нэмэгдэл	12,438,237.9	11,698,838.7	739,399.2	94.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	476,116.2	483,308.7	(7,192.5)	101.5
210105	Гэрээт ажлын хөлс	1,121,013.1	1,079,671.8	41,341.3	96.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,978,386.9	1,516,262.9	1,462,124.0	50.9
210201	Тэтгэврийн даатгал	1,557,137.2	848,848.6	708,288.6	54.5
210202	Тэтгэмжийн даатгал	217,228.8	40,603.2	176,625.6	18.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	179,383.6	26,388.8	152,994.8	14.7
210204	Ажилгүйдлийн даатгал	50,613.3	6,526.7	44,086.6	12.9
210205	Эрүүл мэндийн даатгал	974,024.0	593,895.7	380,128.3	61.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,752,946.3	3,575,064.6	177,881.7	95.3
210301	Гэрэл, цахилгаан	699,493.0	647,845.6	51,647.4	92.6
210302	Түлш, халаалт	2,438,328.1	2,339,239.6	99,088.5	95.9
210303	Цэвэр, бохир ус	203,138.2	175,993.1	27,145.1	86.6
210304	Байрны түрээс	411,987.0	411,986.4	0.6	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,164,675.5	2,156,065.7	8,609.8	99.6
210401	Бичиг хэрэг	92,688.8	88,745.7	3,943.1	95.8
210402	Тээвэр, шатахуун	1,810,513.8	1,786,181.9	24,331.9	98.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	147,896.5	163,406.5	(15,510.0)	110.5
210404	Ном, хэвлэл	3,466.8	2,737.2	729.6	79.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,271.5	10,077.7	1,193.8	89.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	98,838.1	104,916.7	(6,078.6)	106.2
2105	Нормативт зардал	3,783,470.0	3,781,842.9	1,627.1	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,268.1	33,289.8	(21.7)	100.1
210502	Хоол, хүнс	669,853.0	668,295.2	1,557.8	99.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,080,348.9	3,080,258.0	90.9	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,353,514.4	1,353,027.1	487.3	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	494,256.1	492,227.9	2,028.2	99.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	191,670.0	179,134.4	12,535.6	93.5
210604	Урсгал засвар	667,588.3	681,664.9	(14,076.6)	102.1
2107	Томилолт, зочны зардал	76,031.2	75,642.2	389.0	99.5
210702	Дотоод албан томилолт	75,872.8	75,483.8	389.0	99.5
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	158.4	158.4	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,478,266.8	4,431,417.9	46,848.9	99.0



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ЖИЛИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,537,256.3	3,528,543.0	8,713.3	99.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	26,886.7	24,365.9	2,520.9	90.6
210803	Даатгалын үйлчилгээ	700,380.4	699,635.1	745.3	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,970.1	53,052.4	17,917.7	74.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	18,540.4	18,337.3	203.1	98.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,096.0	27,823.2	272.8	99.0
210807	Газрын төлбөр	95,970.2	79,553.7	16,416.5	82.9
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	166.7	107.3	59.4	64.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,036,049.1	1,028,450.0	7,599.1	99.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	435,651.4	433,324.5	2,326.9	99.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,397.7	595,125.5	5,272.2	99.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,886,019.7	9,883,417.6	2,602.1	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	55,600.8	55,600.8	0.0	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	55,600.8	55,600.8	0.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,830,418.9	9,827,816.8	2,602.1	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	455,974.8	453,372.7	2,602.1	99.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500.0	4,500.0	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,369,944.1	9,369,944.1	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,741,942.2	10,227,056.9	514,885.3	95.2
220001	Барилга байгууламж	2,305,200.0	2,559,017.4	(253,817.4)	111.0
221001	Их засвар	357,000.0	-	357,000.0	-
224001	Стратегийн нөөц хөрөнгө	8,079,742.2	7,668,039.5	411,702.7	94.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	86,200,696.0	81,201,428.2	4,999,267.8	94.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	81,564,590.7	76,556,989.9	5,007,600.8	93.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	81,564,590.7	76,556,989.9	5,007,600.8	93.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,636,105.3	4,644,438.3	(8,333.0)	100.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,636,105.3	4,627,619.8	8,485.5	99.8
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	9.2	8.4	0.7	92.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	38	38	0	100.0
610001	Төсвийн байгууллага	38	38	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	4,561	4,196	365	92.0
620001	Удирдах ажилтан	41	40	1	97.6
620002	Гүйцэтгэх ажилтан	3,956	3,612	344	91.3
620003	Үйлчлэх ажилтан	338	334	4	98.8
620004	Гэрээт ажилтан	226	210	16	92.9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	4,561	4,196	365	92.0
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	3,997	3,652	345	91.4
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	338	334	4	98.8
650010	Гэрээт ажилтан	226	210	16	92.9



5. Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.03.25	Аудитын нэр:	Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудит	Аудитын код: САГ-2019/3/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Онцгой байдлын ерөнхий газар		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас			Алдаа, зөрчилтэй асуудал	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	3	4	5			9	10
1	Хөрөнгө оруулалт, их засварын санхүүгийн тайлан, тодруулгыг тулган шалгахад ХУД-ийн Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах 65 дугаар ангийн барилга, угсралтын ажлыг "Назу констракшн" ХХК 2011-2016 онд хийж гүйцэтгэсэн боловч гадна зам талбайн тохижилтын ажлаа хийгээгүй, уг барилгыг Улсын комисст хүлээлгэж өгөөгүйгээс 859.2 сая төгрөгийн барилга дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй байна.	859.2	Зөвлөмж өгөх.			Дарга, хошууч генерал Ерөнхий нягтлан бодогч, дэд хурандаа	Т.Бадрал Г.Бат-Эрдэнэ
2	Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан 2013-2015 онд үүссэн 4 аж ахуйн нэгжтэй холбоотой 14.2 сая төгрөгийн, 2 иргэнтэй холбоотой 13.9 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	28.2	Зөвлөмж өгөх.			Дарга, хошууч генерал Ерөнхий нягтлан бодогч, дэд хурандаа	Т.Бадрал Г.Бат-Эрдэнэ
	Нийт	887.4					